



ЧИЗДСЭН 1993 ОСНОУ АДХ-Р ЗАХИРГААНЫХ ХҮРЛҮҮЛ

БНМАУ

УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ДЕПУТАТУУДЫН
ХҮРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ
ТОГТООЛ

1988 оны 09 сарын 22-дөрөн

дугаар 235.

Улаанбаатар хот

Иргэний гэр бүлийн байдлыг буртгэх хэлтэс, Гэрлэх ёслолын ордон, Арбитр, авто баазын талаар авах зарим арга хэмжээний тухай

Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаанаас ТОГТООХ нь:

1. Батлагдсан чалингийн фонддоо багтаан хотын арбитрийн арбиторчид, Иргэний гэр бүлийн байдлыг буртгэх хэлтсийн байчаагчдыг ажилд томилох, чөлөөлөх, тэдний чалинг тогтоох асуудлыг хотын гүйцэтгэх захиргаанд танилцуулсны үндсэн дээр мөрдөж байгаа чалингийн схемийг баримтлан түүгээрээ зохих журмаар шийдвэрлэж байхыг Хотын еренхий арбитор н.Алтанцэцэг, Иргэний гэр бүлийн байдлыг буртгэх хэлтэс /н.Тогоо/-д зөвшөөрсүгэй.

2. Гэр бүл болохоор Гэрлэх ёслолын ордноор үйлчлүүлж танилцах иргэдийн асуудлыг эрхлэх зохион байгуулагч нэгийн орон тоог энэ оны 9 дүгээр сарын 15-наас эхлэн туршилтын журмаар ажиллуулж түүнд танилцуулах үйлчилгээ хийсний орлого болон Иргэний гэр бүлийн байдлыг буртгэх хэлтэс, Гэрлэх ёслолын ордны чалингийн фондын хэмнэгдлээс сард 550 төгрөгийн чалин олгох байхыг Иргэний гэр бүлийн байдлыг буртгэх хэлтэс, Гэрлэх ёслолын ордон / /н.Тогоо/-д зөвшөөрсүгэй.

3. Байгууллагын бие даасан эрхийг өргөтгөх зорилгоор авто баазын ашиглалт, еренхий механикийг ажилд томилох, чөлөөлөх асуудлыг хотын гүйцэтгэх захиргаанд танилцуулсны үндсэн дээр түүгээрээ шийдвэрлэж байхыг хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны авто бааз /н.Мижиддорж/-д зөвшөөрсүгэй.

УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРГААНЫ ДАРГА

С.МОНХЖАРГАЛ

УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРГААНЫ ХАРИУЧЛАГАТАЙ НАРИИН
БИЧИЙН ДАРГА

Д.АЛГИА